

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/150/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/145
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ДАВААДУЛАМ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцсийн тооллогыг гүйцэтгэхдээ 62,074.7 мянган төгрөгийн бараа материалыг биетээр тоолоогүй, 6,450.0 мянган төгрөгийн барилгын материалыг их хэмжээгээр бэлтгэн, үр ашиггүй удаан хадгалж нөөцөлсөн, 2,647.1 мянган төгрөгийн авлага, 4,419.7 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тайлант оны 11, 12 дугаар саруудад нийт 88,260.5 мянган төгрөгийн цалин хөлсийг анхан шатны баримт, холбогдох тооцоо бодсон баримтгүй олгосон зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэнтэй тус

тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Тасалбар болголт” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 21,105.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 5,479.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд тусган тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhir/Alban bichig 2023/ A4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>44,280,566.22</u>	<u>144,533,633.86</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	79,811,822.64
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	79,811,822.64
3121	Төгрөг	-	79,811,822.64
31211	Төрийн сангийн харилцах		79,811,822.64
33	АВЛАГА	2,647,111.22	2,647,111.22
335	Бусад авлага	2,647,111.22	2,647,111.22
3351	Байгууллагаас авах авлага	1,717,111.22	1,717,111.22
3352	Хувь хүмүүсээс авах авлага	930,000.00	930,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,633,455.00	62,074,700.00
354	Хангамжийн материал	41,633,455.00	62,074,700.00
35410	Бичиг хэргийн материал	1,409,973.00	1,646,573.00
35420	Аж ахуйн материал	39,286,642.00	58,393,142.00
35440	Түлш, шатах тослох материал		118,400.00
35460	Хүнсний материал	891,840.00	1,826,485.00
35470	Бусад хангамжийн материал	45,000.00	90,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,425,726,843.33</u>	<u>2,371,959,263.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,425,726,843.33	2,371,959,263.51
392	Биет хөрөнгө	2,414,248,843.33	2,360,481,263.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,301,287,207.74	2,301,287,207.74
39202	Хуримтлагдсан элэгдэл	108,279,580.44	162,622,655.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,496,804.00	81,276,204.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	39,294,113.60	42,489,116.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,865,041.89	129,370,541.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	38,870,709.68	56,484,155.31
39209	Зам, гүүрний байгууламж	42,912.00	42,912.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	159,776,073.00	159,776,073.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	52,259,697.39	60,160,653.27
39217	Ном	10,484,905.81	10,484,905.81
393	Биет бус хөрөнгө	11,478,000.00	11,478,000.00
39301	Программ хангамж	536,500.00	536,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	536,500.00	536,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,478,000.00	11,478,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,470,007,409.55</u>	<u>2,516,492,897.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,693,887.12</u>	<u>4,419,725.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,693,887.12	4,419,725.00
413	Өглөг	6,693,887.12	4,419,725.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	425,000.00	425,000.00
4136	Бусад өглөг	6,268,887.12	3,994,725.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,268,887.12	3,994,725.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,463,313,522.43</u>	<u>2,512,073,172.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,463,313,522.43	2,512,073,172.37

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	675,096,458.81	675,096,458.81
51101	Өмч: - төрийн	675,096,458.81	675,096,458.81
512	Хуримтлагдсан үр дүн	1,788,217,063.62	1,836,976,713.56
51210	Өмнөх үеийн үр дүн	12,897,933.24	(1,370,021,233.13)
51220	Тайлант үеийн үр дүн	1,094,441,131.96	2,526,119,948.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	680,877,998.42	680,877,998.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,470,007,409.55</u>	<u>2,516,492,897.37</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,874,526,147.21	3,415,497,116.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,672,898,522.21	2,481,564,498.33
120	Нийтлэг татварын бус орлого	1,149,658,822.21	2,481,564,498.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,149,658,822.21	2,481,564,498.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,503,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,149,658,822.21	2,480,060,698.33
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	523,239,700.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	523,239,700.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	201,627,625.00	933,932,617.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	708,349,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		708,349,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,623,825.00	12,504,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,623,825.00	12,504,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	152,003,800.00	213,078,317.99
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	152,003,800.00	213,078,317.99
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	780,085,015.25	889,377,168.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	780,085,015.25	889,377,168.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	730,292,611.05	873,880,253.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,503,960.38	430,252,037.08
210101	Үндсэн цалин	345,605,745.47	335,373,388.17
210102	Нэмэгдэл	44,075,692.00	72,158,038.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,279,403.91	-
210104	Урамшуулал	14,543,119.00	22,720,610.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,262,661.91	88,894,705.15
210201	Тэтгэврийн даатгал	40,599,123.13	26,560,223.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,331,096.57	4,346,497.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,344,497.88	3,477,197.55
210204	Ажилгүйдлийн даатгал	726,940.39	862,003.88
210205	Эрүүл мэндийн даатгал	7,261,003.94	53,648,782.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,311,566.00	173,723,326.00
210301	Гэрэл, цахилгаан	5,358,366.00	2,339,445.00
210302	Түлш, халаалт	137,682,500.00	171,143,881.00
210303	Цэвэр, бохир ус	270,700.00	240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,437,225.00	537,600.00
210401	Бичиг хэрэг	984,425.00	
210402	Тээвэр, шатахуун	1,835,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	202,500.00	
210404	Ном, хэвлэл	67,800.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	62,500.00	

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	285,000.00	537,600.00
2105	Нормативт зардал	41,481,749.00	72,006,805.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	
210502	Хоол, хүнс	38,784,449.00	72,006,805.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,197,300.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432,000.00	2,880,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	432,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,880,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,363,448.76	104,585,779.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	209,000.00	16,041,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,275,000.00	5,492,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,879,448.76	83,052,479.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,792,404.20	15,496,915.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,122,100.00	15,496,915.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		5,542,015.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,334,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,869,600.00	9,954,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	918,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,670,304.20	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,670,304.20	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,094,441,131.96</u>	<u>2,526,119,948.27</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,094,441,131.96</u>	<u>2,526,119,948.27</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	724,867,325.00	935,436,417.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,503,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,503,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,503,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,503,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	724,867,325.00	933,932,617.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	523,239,700.00	708,349,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		708,349,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	523,239,700.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,623,825.00	12,504,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,623,825.00	12,504,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	152,003,800.00	213,078,317.99
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	152,003,800.00	213,078,317.99
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	724,867,325.00	834,519,095.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	724,867,325.00	834,519,095.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,708,805.80	795,531,630.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,469,758.80	455,417,204.35
210101	Үндсэн цалин	266,069,390.87	346,444,262.52
210102	Нэмэгдэл	115,501,804.00	93,750,043.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,725,986.93	-
210104	Урамшуулал	18,172,577.00	15,222,898.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,845,400.00	65,976,700.00
210201	Тэтгэврийн даатгал	38,189,572.14	44,864,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,245,827.86	5,278,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,309,400.00	4,222,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	827,300.00	1,057,306.63
210205	Эрүүл мэндийн даатгал	8,273,300.00	10,554,493.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,132,700.00	173,723,326.00
210301	Гэрэл, цахилгаан	5,250,200.00	2,339,445.00
210302	Түлш, халаалт	137,682,500.00	171,143,881.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,144,525.00	-
210401	Бичиг хэрэг	717,225.00	-
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	252,500.00	-
210404	Ном, хэвлэл	335,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,929,800.00	-

2105	Нормативт зардал	27,986,322.00	58,330,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	
210502	Хоол, хүнс	24,686,422.00	58,330,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,799,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,871,100.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	8,871,100.00	11,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	-
210702	Дотоод албан томилолт	300,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00	6,347,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	1,503,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,843,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,459,000.00	24,736,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,399,000.00	17,316,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,060,000.00	7,420,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,158,519.20	38,987,465.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,488,215.00	38,987,465.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,366,115.00	29,032,565.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,334,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,869,600.00	9,954,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	918,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,670,304.20	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,670,304.20	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	100,917,322.64
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	21,105,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	21,105,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	21,105,500.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		21,105,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(21,105,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	79,811,822.64
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	79,811,822.64

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,922,258.69	12,897,933.24	1,368,916,650.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,096,458.81	680,922,258.69	12,897,933.24	1,368,916,650.74
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-44,260.27		-44,260.27
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
7	Тайлант үеийн үр дүн			1,094,441,131.96	1,094,441,131.96
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,107,339,065.20	2,463,313,522.43
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,107,339,065.20	2,463,313,522.43
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-2,477,360,298.33	-2,477,360,298.33
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	-1,370,021,233.13	-14,046,775.90
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
16	Тайлант үеийн үр дүн			2,526,119,948.27	2,526,119,948.27
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,156,098,715.14	2,512,073,172.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	944,083,000.00	843,119,695.35	100,963,304.65	89.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	944,083,000.00	843,119,695.35	100,963,304.65	89.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	915,043,600.00	814,087,130.35	100,956,469.65	88.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	544,678,300.00	455,417,204.35	89,261,095.65	83.61
210101	Үндсэн цалин	418,064,800.00	346,444,262.52	71,620,537.48	82.87
210102	Нэмэгдэл	116,551,900.00	93,750,043.35	22,801,856.65	80.44
210104	Урамшуулал	10,061,600.00	15,222,898.48	(5,161,298.48)	151.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,084,700.00	65,976,700.00	2,108,000.00	96.90
210201	Тэтгэврийн даатгал	46,297,600.00	44,864,100.00	1,433,500.00	96.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,446,800.00	5,278,200.00	168,600.00	96.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,357,500.00	4,222,600.00	134,900.00	96.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,089,300.00	1,057,306.63	31,993.37	97.06
210205	Эрүүл мэндийн даатгал	10,893,500.00	10,554,493.37	339,006.63	96.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,801,300.00	173,723,326.00	9,077,974.00	95.03
210301	Гэрэл, цахилгаан	11,167,900.00	2,339,445.00	8,828,455.00	20.95
210302	Түлш, халаалт	171,393,400.00	171,143,881.00	249,519.00	99.85
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	240,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	58,330,800.00	58,330,800.00	-	100.00
210502	Хоол, хүнс	58,330,800.00	58,330,800.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	11,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	11,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,848,100.00	6,347,000.00	501,100.00	92.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,901,000.00	1,503,800.00	397,200.00	79.11
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,947,100.00	4,843,200.00	103,900.00	97.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,300,400.00	43,292,100.00	8,300.00	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,879,800.00	35,871,500.00	8,300.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,420,600.00	7,420,600.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,039,400.00	29,032,565.00	6,835.00	99.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,039,400.00	29,032,565.00	6,835.00	99.98
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,039,400.00	29,032,565.00	6,835.00	99.98
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	944,083,000.00	922,931,517.99	21,151,482.01	97.76
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	708,349,400.00	708,349,400.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	708,349,400.00	708,349,400.00	-	100.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	233,832,600.00	213,078,317.99	20,754,282.01	91.12
132001	Орон нутгийн төсвөөс	233,832,600.00	213,078,317.99	20,754,282.01	91.12
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,901,000.00	1,503,800.00	397,200.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,901,000.00	1,503,800.00	397,200.00	79.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	79,811,822.64	(79,811,822.64)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	36.00	36.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,504,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,504,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,954,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,954,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,954,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,504,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,504,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,504,900.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих төлөвших үй явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг эх асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлсон. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоол “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,485.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	79,811.8	79,811.8
Авлага	2,647.1	2,647.1	-
Бараа материал	41,633.5	62,074.7	20,441.2
Үндсэн хөрөнгө	2,425,726.8	2,371,959.2	(53,767.6)
Нийт хөрөнгийн дүн	2,470,007.4	2,516,492.8	46,485.4
Өглөг	6,693.9	4,419.7	(2,274.2)
Засгийн газрын хувь оролцоо	675,096.5	675,096.5	-
Хуримтлагдсан үр дүн	1,107,339.1	1,156,098.7	48,759.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	680,877.9	680,877.9	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,470,007.4	2,516,492.8	46,485.4

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 79,811.8 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй нь өмнөх онд үүссэн авлагыг тайлант онд барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,441.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 4,521.0 мянган төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авч, аж ахуйн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 53,767.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлээс шалтгаалсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 21,105.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 5,479.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 2,274.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгууллагад төлөх өглөгийг барагдуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 708,349.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 233,832.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,901.0 мянган төгрөг, нийт 944,083.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 8 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 944,083.0 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 708,349.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 233,832.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,901.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 708,349.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 213,078.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 1,503.8 мянган төгрөг, нийт 922,931.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 834,519.1 мянган төгрөгийг зарцуулж, 79,811.8 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 843,119.7 мянган төгрөг буюу 89,3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 89,261.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9,077.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 501.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802-Ерөнхий боловсрол	944,083.0	843,119.7	100,963.3	89.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 12,504.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, бараа үйлчилгээний зардалд 2,550.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 9,954.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй, харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах, батлагдсан төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй, он дамжсан авлага, өр төлбөрийг даруй барагдуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 3 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 710,250.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,653.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,990.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 89,261.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9,077.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 501.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8.3 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторов дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 134 мэдээллийг хугацаандаа, 36 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын ажил гүйлгээнээс 32,089.5 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, холбогдох албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 52,369.2 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 1,275.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 50,974.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 119.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнээс тайлант онд 50,974.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 119.7 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Өмнөх оны 1,275.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарч байна. Хэрэгжилт 66.7 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	50,974.5	3	50,974.5	75.0
Төлбөрийн акт	1	1,275.0	-	-	0.0
Зөвлөмж	1	119.7	1	119.7	100.0
Нийт дүн	6	52,369.2	4	51,094.2	66.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 219,104.5 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс, 163,852.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, 55,252.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 163,852.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Захирлын 2022 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/17 дугаар "Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай" тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэхдээ 62,074.7 мянган төгрөгийн бараа материалыг биетээр тоолоогүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн бараа материалын тооллогыг хуульд заасан хугацаанд гүйцэтгэж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд аж ахуйн материалын дансанд 6,450.0 мянган төгрөгийн барилгын материал үлдэгдэлтэй, их хэмжээгээр бэлтгэн, үр ашиггүй удаан хадгалж нөөцөлсөн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны эцэст 2,647.1 мянган төгрөгийн авлага, 4,419.7 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант оны 11, 12 дугаар саруудад нийт 88,260.5 мянган төгрөгийн цалин хөлсийг анхан шатны баримт, холбогдох тооцоо бодсон баримтгүй олгосон нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 4 байгууллагын 52,180.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаж байх.

2. Авлага, өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант оны эцэст он дамжсан 2,647.1 мянган төгрөгийн авлага, 425.0 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, он дамжсан авлага, өр төлбөрийг даруй барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Захирлын 2022 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/17 дугаар "Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай" тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэхдээ 62,074.7 мянган төгрөгийн бараа материалыг биетээр тоолоогүй	1	62,074.7			1	62,074.7			-	-	-	-
Тайлант онд аж ахуйн материалын дансанд 6,450.0 мянган төгрөгийн барилгын материал үлдэгдэлтэй, их хэмжээгээр бэлтгэн, үр ашиггүй удаан хадгалж нөөцөлсөн	1	6,450.0			1	6,450.0			-	-	-	-
Тайлант оны эцэст 2,647.1 мянган төгрөгийн авлага, 4,419.7 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	7,066.8			1	7,066.8			-	-	-	-
Тайлант оны 11, 12 дугаар саруудад нийт 88,260.5 мянган төгрөгийн цалин хөлсийг анхан шатны баримт, холбогдох тооцоо бодсон баримтгүй олгосон	1	88,260.5			1	88,260.5						
Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 4 байгууллагын 52,180.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	52,180.4					1	52,180.4				
Тайлант оны эцэст он дамжсан 2,647.1 мянган төгрөгийн авлага, 425.0 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй	1	3,072.1					1	3,072.1				
Дүн	6	219,104.5			4	163,852.0	2	55,252.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 134 мэдээллийг хугацаандаа, 36 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын ажил гүйлгээнээс 32,089.5 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	32,089.5					1	32,089.5		
Дүн	1	32,089.5					1	32,089.5		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn